



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 12 сарын 18 өдөр

Дугаар А/789

Булган сум

「Хөдөө аж ахуйн салбарын мэргэжилтнүүдийг
чадавхжуулах сургалт зохион байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, аймгийн Засаг даргын 2024 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн А/633 дугаар “Хөтөлбөр, төлөвлөгөө, арга хэмжээний зардлыг батлах тухай” захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын Засаг даргын Тамгын газрын Хөдөө аж ахуйн тасгийн албан хаагчдыг чадавхжуулах, цаашдын бодлого чиглэлийг хэрэгжүүлэх арга зүйн зөвлөгөө өгч, анхаарах шаардлагатай асуудлын талаар хэлэлцэх сургалт, зөвлөгөөнийг 2024 оны 12 дугаар сарын 19-20-ны өдрүүдэд аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газарт зохион байгуулсугай.

2.Дээрх зөвлөгөөнийг зохион байгуулахад шаардагдах зардлыг хавсралтаар баталж, 1,868,000 (нэг сая найман зуун жаран найман мянга) төгрөгийг Үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын арга хэмжээний зардлаас, 2,412,000 (хоёр сая дөрвөн зуун арван хоёр мянга) төгрөгийг “Газар тариалангийн тогтвортой хөгжил” хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас тус тус санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-д зөвшөөрсүгэй.

3.Сургалтыг бэлтгэл сайтай зохион байгуулж, холбогдох баримт бичгийг бүрдүүлж ажиллахыг аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар (Ч.Амгалан)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР



6324011179

Аймгийн Засаг даргын 2024 оны
12 дугаар сарын 18-ны/ний өдрийн А/789 дугаар
захирамжийн хавсралт

ХӨДӨӨ АЖ АХУЙН ТАСГИЙН МЭРГЭЖИЛТНҮҮДИЙГ ЧАДАВХЖУУЛАХ
СУРГАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХАД ШААРДАГДАХ ЗАРДАЛ

д/д	Зардлын нэр	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт дүн
1	2	3	4	5
1	Сургалтын материал	60	31,200	1,868,000
2	Цайны завсарлага	60	40,200	2,412,000
	Бүгд дүн			4,280,000